



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

СЭДЭВ#6 Саналуудыг нэгтгэн дүгнэж эцсийн шийдвэрт тусгах нь
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА

Joan McEwen
Long Term Technical Advisor

Хэлэлцүүлгийн дараах үйл ажиллагаа

Хэлэлцүүлгийн үйл ажиллагаа дуусаж, шийдвэр (төсөл, шинэ зохицуулалт, гэх мэт) гарлаа Энэ бол үйл явцын төгсгөл биш юм.

Процессийг эргэн нэг харж давуу тал болон сул тал юу байв гэдгийг олж харах нь зүйтэй.....Ололттой зүйл нь юу байв? Дутагдалтай зүйл нь юу байв?

Эргэн нэг хянаснаар одоогийн үйл явцаа сайжруулж болно.



Яагаад эргэн харах ёстой гэж?

Хэлэлцүүлгийн үйл явцаас гарсан шийдвэрийн үр дүнг үнэлэх нь чухал юм.

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь зөвхөн үр дүн төдийгүй, алдаанаас суралцаж, дараагийн удаа үйл явцыг сайжруулахад тусална.

Та юу хийсэн, хэрхэн хийсэн талаар эргэж харах нь хэлэлцүүлэг, талуудын оролцооны "тэргүүн туршлага" -ыг бий болгоход тань тусална.

Хяналт шинжилгээ, үнэлгээ

Аливаа хэлэлцүүлгийн явцад болон дууссаны дараа хяналт үнэлгээ, шинжилгээ хийж байх нь нэн чухал.

Үнэлгээ хийх нь хэлэлцүүлгийн зорилго хангагдсан эсэхэд хариулт өгөхөөс гадна бусад тооцоолоогүй үр дүн бий болсон эсэхийг тогтооход тусална.

Хэлэлцүүлгийн явцаас гарсан үр дүн (эерэг болон сөрөг)-д дүн шинжилгээ хийснээр явцыг хянаж, цаашид зорилгодоо хүрэхэд шаардлагатай зүйлсийг олж харах болно.

Үндсэндээ ХШҮ-ээр дараах асуултууд гарч ирдэг – энэхүү хэлэлцүүлгийн үеэр юу хийгдэв? Энэ тохиолдолд зөвлөгөөн хийхэд юу хийхээр төлөвлөсөн бэ? Хэрэв тийм бол яаж? Хэрэв үгүй бол яагаад?



Хяналт шинжилгээ, үнэлгээний асуултууд

Үнэлгээний зорилго юу вэ?

Хэн, юуны талаар мэдэхийг хүсч байна?

Хэлэлцүүлгийн явцын ялгаатай хэсгүүдийг хүмүүс, албан байгууллагууд сонирхож байна уу?

Ямар мэдээлэл цугларсан, ямар аргаар санал, зөвлөмжийг хүлээж авсан бэ?

Үнэлгээ хийхэд ямар нөөц (цаг хугацаа, санхүүжилт, ур чадвар) шаардлагатай вэ?

Дараагийн алхмууд.....

Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нь оролцогч талуудын шийдвэр гаргах, хариуцлага нэмэгдүүлэх, суралцах мөн чадавхийг бэхжүүлэх зэргээр тухайн хэлэлцүүлгийн зорилгыг хэрэгжүүлэхэд ач тустай.

ХШҮ нь санал болгож буй төсөл, үйл ажиллагаанд үзүүлэх хэлэлцүүлгийн үр нөлөөг үнэлэхэд тусалдаг.

Хэрэв хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд өөрчлөлт хийнэ гэвэл шинэ хэлэлцүүлэг хийх шаардлага гарч болно.

Хэрэв тийм бол та хэлэлцүүлгийн үйл ажиллагааны эхэнд эргэж очих хэрэгтэй болно.